

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/143/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2022 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторовын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч:
Ш.Мөнхбаяр
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: О.Мягмарсүрэн
Утас: 70373089 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**


45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

**ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ
ДАРХАН-УУЛ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Г.БУЛГАНЧИМЭГ ТАНАА**

2022.02.23 № 114

тантай _____ -ны № _____

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, болон мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Худалдан авалтын анхан шатны дэмжих баримтгүй болон төлбөрийн цахим баримтгүй ажил гүйлгээ 7,079.2 мянган төгрөг, дахин үнэлгээний 107,483.1 мянган төгрөгийн нэмэгдэл тодорхой бус, төрийн өмчийн түрээсийн төвлөрүүлээгүй орлого 10,843.5 мянган төгрөг, шилэн дансны нэгдсэн системд тайлант оны мэдээллийг оруулаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл 23.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1, 13.7, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, оршин байх, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

009020113


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,592,695.24	21,142,581.24
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	564,809,831.53	538,573,016.97
	Нийт хөрөнгийн дүн	592,402,526.77	559,715,598.21
	Нийт өр төлбөрийн дүн	6,760,001.86	7,998,428.36
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	585,642,524.91	551,717,169.85
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	592,402,526.77	559,715,598.21
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	128,218,177.73	62,574,519.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	71,232,934.98	95,555,784.06
	Үйл ажиллагааны үр дүн	56,985,242.75	(32,981,265.06)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	56,985,242.75	(32,981,265.06)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	528,657,282.16	584,698,434.91
	Тайлант оны үр дүн	56,985,242.75	(32,981,265.06)
	Эцсийн үлдэгдэл	585,642,524.91	551,717,169.85
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	73,145,624.00	69,020,092.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	60,337,773.09	66,232,003.00
	Үйл ажиллагааны ЦМГ	12,807,850.91	2,788,089.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	880,000.00	1,800,000.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	11,927,850.91	988,089.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,690,639.33	14,618,490.24
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,618,490.24	15,606,579.24

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төв нь иргэн, аж ахуйн нэгж болон гарааны бизнес эрхлэгчдийг тэдний бизнесийн үйл ажиллагаа үйлдвэрлэл, үйлчилгээнд арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар зах зээлд бие даан даан хөгжих чадвартай бизнес эрхлэгч болгон төлөвшүүлэх зорилготойгоор сургалт, зөвлөгөө, бизнес инкубацийн үйл ажиллагааг явуулж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон төслийн сургалтын зардал болон Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Жижиг дунд үйлдвэрийн Дархан-Уул төвийн “Дарханд үйлдвэрлэв” дэлгүүрт олгож буй борлуулалтын дэмжлэгийн үр дүнг дараагийн аудитаар авч үзнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 244,597.1 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илрүүлснээс 20,486.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 38,643.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 325.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 185,141.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 9 алдаа, зөрчлийн дүн 223,785.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 5,704.7 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнг 14,068.4 мянга, санхүүгийн байдлын тайлангийн тайлант оны үр дүнг 5,090.9 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн;
- Даатгуулагчаас төлсөн НДШ-ийн зардал 1,327.0 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд тус тус тайлагнасан.

4.2 Төлбөрийн акт

1. Цалингийн тооцооны хүснэгтээс гарт олгох дүнг зөрүүтэй тооцоолсноос захирал Г.Булганчимэгт 134,625.0 төгрөг, нягтлан бодогч Г.Сугарнямд 75,573.0, харуул Д.Саруултуяад 115,110.0 төгрөгийг тус тус илүү тооцож олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 325.3 мянган төгрөгийг Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төвийн харилцах дансанд төвлөрүүлэх, Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Тайлант онд Шилэн дансны нэгдсэн системд байршуулах 5.0 сая төгрөгөөс дээш 13,260.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 9,191.3 мянган төгрөгийн хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 8 тушаал, 7,998.4 мянган төгрөгийн өр, 1,115.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэр, нийт 31,564.7 мянган төгрөгийн мэдээг байршуулаагүй зөрчлийг давтан гаргаж байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг 7 хоногийн дотор, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг 7 хоногийн дотор мэдээлэх гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн байршуулж ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Тайлант оны 17,952.2 мянган төгрөгийн худалдан авалтыг анхан шатны баримт, цахим баримтын ebarimt.mn системтэй тулган шалгахад 7,079.2 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримтыг харилцагч байгууллагуудаас гаргуулан аваагүй, ажлын тайлан, гэрээг дүгнэж акт үйлдээгүй зэрэг анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянах, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах, Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Дахин үнэлгээний нэмэгдэл 107,483.1 мянган төгрөг санхүүгийн тайланд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын Дахин үнэлгээ 4.42-д “Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн

дансны үнэ нэмэгдсэн хэмжээгээр дахин нэмэгдэл дансны кредитэд бичнэ”, 3 дугаар хавсралт “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 4.20-д “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр гарсан үнийн өсөлтийг “Дахин үнэлгээний нэмэгдэл” гэсэн хэсэгт үзүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгө тус бүрт хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусган оруулж, данснаас хасагдсан хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг УССНБОУС 17 Үндсэн хөрөнгө стандартын 57-д заасны дагуу хасалт хийж, үлдэгдлийг үнэн зөв тайлагнах

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Албан хаагчдын албан тушаалын цалинг Эрүүл мэндийн салбарын цалингийн сүлжээгээр тогтоосноос 931.7 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-тэй нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтад заасны дагуу албан хаагчдын цалингийн сүлжээг тогтоох, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

3. Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 0394114 тоот Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох актаар Нягтлан бодогч Г.Сугарнямын хөдөлмөрийн чадвар алдалтыг 70 хувиар 1 жилийн хугацаатай тогтоосон байна. Энэ хугацаанд цалин хөлснөөс 463.5 мянган төгрөгийн албан татварыг суутган тооцсон байна

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.т “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хөдөлмөрийн чадвараа алдсан албан хаагчийн цалин, хөлснөөс албан татвар ногдуулахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

4. Цалингийн зардалтай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Төрийн өмчийг түрээслүүлэх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоогоогүй, мөн ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр төрийн өмчийн барилга байгууламжид түрээслэгчийн зардлаар урсгал засвар хийлгэж, түрээсийн төлбөрөөс чөлөөлсөн байна..

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ын 1-д “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно”, 4-д “Төрийн өмчийн бүртгэлд байгаа барилга байгууламжид түрээслэгчийн санхүүжилтээр урсгал засвар хийх тохиолдолд түрээсийн төлбөрөөс суутган тооцох асуудлыг засвар хийхээс өмнө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар"-ын дагуу төрийн өмчийн түрээсийн төлбөрийг шинэчлэн тогтоох, түрээсийн төлбөрөөс чөлөөлөх асуудлыг ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлж байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

5. Орлого төлөвлөлттэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тус газар нь тайлант онд төлөвлөгөөнд тусгагдаагүй 65,420.1 мянган төгрөгийн орлого олсон нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 29,275.0 мянган төгрөг, төрийн өмчийн түрээсийн орлого 36,145.1 мянган төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.2-т "төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого", Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ыг баримталж ажиллаагүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.5.2 дахь заалтууд, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ыг баримтлан үйл ажиллагааны орлогыг төлөвлөж батлуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

6. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан 2017/ДАА/01-0143 тоот "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний дагуу түрээсийн орлого 36,145.1 мянган төгрөгийн 30 хувь 10,843.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.2-д "төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-д "төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна. хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ"-тэй нийцэхгүй байна.

6.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.5.2 дахь заалтууд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г мөрдөж ажиллах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	11	244.6	2	20.5	1	0.3	2	38.6	6	185.5
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	11	244.6	2	20.5	1	0.3	2	38.6	6	185.5